



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 3 сарын 12 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Бүртгэлд хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 264 дүгээр тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөх журам”-ын 4.4 дэх заалт, улсын ахлах байцаагчийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.6 дахь заалтыг зөрчсөн хавсралтад заасан нэр бүхий хуулийн этгээдүүдийг тухайн зөрчлийг гаргаснаас хойш 3 жилийн хугацаагаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагаанд оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулсугай.

Хоёр. Энэ тушаалын нэгдүгээр зүйлд заасан тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах хугацаа дууссан хуулийн этгээдийг тухай бүр жагсаалтаас хасч, нийтэд мэдээлж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/-т даалгасугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/, Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар /Б.Батцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа мөрдөж ажиллахыг бүх шатны төсвийн эрх захирагч-захиалагч нарт зөвлөсүгэй.

САЙД



Ч.УЛААН

ТЕНДЕРТ ОРОЛЦОХ ЭРХЭЭ ХЯЗГААРЛУУЛСАН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛД
ХАМРУУЛАХ ЭТГЭЭДИЙН НЭРС

№	Гүйцэтгэгч компанийн нэр	Гаргасан зөрчил	Зөрчил гаргасан огноо	Бүртгэлд хамруулах хугацаа дуусгавар болох огноо
1	Түрүү гарав ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн	2011.04.11	2014.04.11
2	Таван талст оргил ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн	2011.04.20	2014.04.20
3	Цамхаг Констракшн ХХК	Голомт банкны Гүйцэтгэлийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2011.04.26	2014.04.26
4	Цацрах цог ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2011.08.11	2014.08.11
5	ЧБББ ХХК	Голомт банкны Урьдчилгаа төлбөрийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.02.01	2015.02.01
6	Хөхийн элч ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа, Урьдчилгаа төлбөрийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.02.08	2015.02.08
7	Дэлгэр констракшн ХХК	Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн	2012.05.11	2015.05.11
8	Дагшин харгуй ХХК	Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.07.10	2015.07.10
9	Медбенефит ХХК	Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.03.21	2015.03.21
10	Анар сан ХХК	Голомт банкны тодорхойлолт	2012.04.16	2015.04.16
11	Бүтээн байгуулалт ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн	2012.05.11	2015.05.11
12	Нарантээл ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.05.11	2015.05.11
13	Номгон Хайрхан ХХК	Хас банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.03.30	2015.03.30
14	Бадмаараг-Өргөө ХХК	Хас банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн	2012.05.11	2015.05.11
15	Сумпакс ХХК	Хас банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.05.10	2015.05.10
16	Мөнхтавилга ХХК	Хас банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2013.07.23	2016.07.23

17	Шинжиан Коммуникейшн констракшн ХХК	Хятадын банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.05.03	2015.05.03
18	Медтех ХХК	Татварын төлөгчийн талаарх албан тоотыг хуурамчаар ирүүлсэн.	2012.03.25	2015.03.25
19	Киль Туул ХХК	Хаан банкны Урьдчилгаа төлбөрийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.04.26	2015.04.26
20	Талст -Өргөө ХХК	Голомт банкны баталгааг хуурамчаар үйлдсэн.	2012.07.30	2015.07.30
21	Фронт гейт ХХК	Хаан банкны Урьдчилгаа төлбөрийн баталгааг хуурамчаар үйлдсэн.	2013.07.19	2016.07.19
22	Бум Констракшн ХХК	Төрийн банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг хуурамчаар үйлдсэн.	2013.08.07	2016.08.07
23	Хүрэл харш ХХК	2011, 2012 оны санхүүгийн тайлан хуурамчаар ирүүлсэн.	2013.08.26	2016.08.26
24	Донж хацу ХХК	Голомт банкны Тендерийн баталгаа/Урьдчилгаа төлбөрийн баталгаа тус тус хуурамчаар үйлдсэн.	2012.12.28	2015.12.28
25	Төмөрхүлэг ХХК	Голомт банкны Урьдчилгаа төлбөрийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2013.03.22	2016.03.22
26	Мон Инж Эм Жи ХХК	Санхүүгийн тайлан хуурамчаар ирүүлсэн.	2013.06.14	2016.06.14
27	Эрай төгс чоно ХХК	Худалдаа хөгжлийн банкны Тендерийн баталгаа хуурамчаар үйлдсэн.	2012.05.02	2015.05.02

* Сангийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 264 дугаар тушаалаар батлагдсан "Бүртгэл хөтлөх журам"-ын 4.5-д тендэрт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг тухайн **зөрчлийг гаргаснаас хойш 3 жилийн хугацаанд Засгийн газрын худалдан авах ажиллагаанд аливаа нэг хэлбэрээр оролцохыг хориглоно гэж заасан.**